

**“ОРХОН ХӨГЖИЛ” ХК**  
**ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2021 он 04 сар 27 өдөр

Дугаар: 01

Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ИРЦИЙН ТУХАЙ БОЛОН  
ХУРЛЫГ ХҮЧИН ТӨГӨЛДӨРТ ТООЦОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн ээлжит хуралд 101210 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигч оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 117437 ширхэг энгийн хувьцааны 86,1% болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн заалт, компанийн дүрмийн 7.4 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 86,1% - ийг эзэмшигч хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА  Х.САРНАЙ



# “ОРХОН ХӨГЖИЛ” ХК

## ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2021 он 04 сар 27 өдөр  
Улаанбаатар хот

Дугаар: 02

### Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 67-р зүйлийн 67.3.8 дах заалт, 72-р зүйл, “Орхон Хөгжил” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04-р сарын 27–ны өдрийн ээлжит хуралд санал хуралтаар ирүүлсэн санал хураах хуудсыг тоолсон Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Орхон Хөгжил” ХК–ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал хураасан дүн дараах байдалтай байгааг хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.  
Үүнд:
  - 1.1 Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах  
Зөвшөөрсөн 101210 ширхэг хувьцаа буюу 100%, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 %, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 % байна.
  - 1.2 2021 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах  
Зөвшөөрсөн 101210 ширхэг хувьцаа буюу 100%, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 %, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 % байна.
  - 1.3 “Орхон Хөгжил” Компаний цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг батлах,  
Зөвшөөрсөн 101210 ширхэг хувьцаа буюу 100%, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 %, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 % байна.
  - 1.4 “Орхон Хөгжил” Компаний Төлөөлөн удирдах зөвлөлийн ногдол ашиг хувиарлахгүй талаар гаргасан тогтоолыг  
Зөвшөөрсөн 101210 ширхэг хувьцаа буюу 100%, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 %, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 % байна.
  - 1.5 Орхон Хөгжил” Компаний Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох  
Зөвшөөрсөн 101210 ширхэг хувьцаа буюу 100%, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 %, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 % байна.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА  Х.САРНАЙ



**“ОРХОН ХӨГЖИЛ” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН**  
**ТОГТООЛ**

2021 он 04 сарын 27 өдөр

Дугаар:01

Улаанбаатар хот

**ТАЙЛАН, ТӨСӨЛ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 63-р зүйлийн 63.5 дах заалт, 2021 оны 04 сарын 27–ний өдрийн тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс оруулж ирсэн тайланг баталсугай.
2. Компанийн 2021 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.
3. Компанийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ОЮУНЖАРГАЛ

**“ОРХОН ХӨГЖИЛ” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 он 04 сар 27 өдөр  
Улаанбаатар хот

Дугаар:02

**НООГДОЛ АШИГ ХУВИАРЛАХГҮЙ  
ТУХАЙ ШИЙДВЭРИЙГ ТАЙЛАГНАХ НЬ**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.6-р заалтууд, 2021 оны 04-рсарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компани нь ноогдол ашиг хувиарлахгүй гэж шийдвэрлэсэн тухай болон түүний үндэслэл тайлбарыг хувьцаа эзэмшигч нарт тайлагнасан болохыг дурьдсугай.

ХУРЛЫН ДАРГА  *Д.Оюунжаргал* Д.ОЮУНЖАРГАЛ

# “ОРХОН ХӨГЖИЛ” ХК ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2021 он 04 сар 27 өдөр  
Улаанбаатар хот

Дугаар: 03

## САНАЛ ХУРААХ ХУУДСЫГ ТООЛСОН ДҮНГИЙН ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.2 дах заалт, 72.1.3 болон 75.4 дэх хэсэг, санал хураах хуудсаар кумулятив аргаар өгсөн саналыг тоолсон дүнг хэлэлцээд **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгуулахаар нэр дэвшсэн хүн тус бүрээр кумулятив аргаар өгсөн саналын тоо нь дараах байдалтай байгааг хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдээлсүгэй. Үүнд:

№	ТУЗ-ийн гишүүд	Саналын тоо	Саналын, %
Ердийн гишүүд			
1	Д.Оюунжаргал	101210	100%
2	Д.Жаргалсайхан	101210	100%
3	Н.Мөнхзул	101210	100%
4	Г.Урантогос	101210	100%
5	Ж.Очирсүх	101210	100%
6	Н.Баттогтох	101210	100%
Хараат бус гишүүд			
1	Б.Соёл-Эрдэнэ	101210	100%
2	С.Ариунбулган	101210	100%
3	Ч.Баянжаргал	101210	100%

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



Х.САРНАЙ

**“ОРХОН ХӨГЖИЛ” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 он 04 сар 27 өдөр

Дугаар: 03

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 заалт, 2021 оны 04-р сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий зургаан хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Д.Оюунжаргал
2. Д.Жаргалсайхан
3. Н.Мөнхзул
4. Г.Урантогос
5. Ж.Очирсүх
6. Н.Баттогтох

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий гурван хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Б.Соёл-Эрдэнэ
2. С.Ариунбулган
3. Ч.Баянжаргал

3. Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Д.ОЮУНЖАРГАЛ



**“ОРХОН ХӨГЖИЛ” ХК**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**  
**ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 он 04 сар 27 өдөр

Дугаар: 04

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**  
**ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 78-р зүйлийн 78.1. дэх заалтыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн анхдугаар хуралд оролцсон нийт 9 гишүүний 100 хувийн саналаар Д.Оюунжаргалыг ТУЗ-ийн даргаар сонгосугай.
2. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, журмаар тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ТУЗ-ийг удирдан зохион байгуулж ажиллахыг Д.Оюунжаргалд үүрэг болгосугай.

**ТУЗ-ийн гишүүд:**



1. Д.Оюунжаргал
2. Д.Жаргалсайхан
3. Н.Мөнхзул
4. Г.Урантогос
5. Ж.Очирсүх
6. Б.Соёл-Эрдэнэ
7. Н.Баттогтох
8. С.Ариунбулган
9. Ч.Баянжаргал

**“ОРХОН ХӨГЖИЛ” ХК**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН**  
**ТОГТООЛ**

2021 он 04 сар 27 өдөр

Дугаар:05

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫГ ТОМИЛОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.8. дах заалт, ТУЗ-ийн даргаас оруулсан саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн анхдугаар хуралд оролцсон нийт 9 гишүүний 100 хувийн саналаар Г.Урантогосыг компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар томилсугай.
2. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан нарийн бичгийн даргын эрх үүргийг үндэслэн Г.Урантогостой байгуулах ажил гүйцэтгэх гэрээг хавсралтаар баталсугай.
3. ТУЗ-ийг төлөөлөн гэрээнд гарын үсэг зурахыг ТУЗ-ийн дарга Д.Оюунжаргалд зөвшөөрсүгэй.
4. Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон ажил гүйцэтгэх гэрээнд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг Г.Урантогост үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  Д.ОЮУНЖАРГАЛ



**“ОРХОН ХӨГЖИЛ” ХК**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН**  
**ТОГТООЛ**

2021 он 04 сар 27 өдөр

Дугаар: 06

Улаанбаатар хот

**ТУЗ-ИЙН ХОРООДЫГ БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 81-р зүйлийн 81.2. дах заалт, ТУЗ-ийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн Аудитын хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
  1. Н.Баттогтох /Дарга/
  2. Н.Мөнхзул
  3. Ч.Баянжаргал
2. ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
  1. Д.Жаргалсайхан /Дарга/
  2. С.Ариунбулган
  3. Ч.Баянжаргал
3. ТУЗ-ийн Цалин урамшууллын хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
  1. Ж.Очирсүх /Дарга/
  2. С.Ариунбулган
  3. Н.Баттогтох
4. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, Хороодын үйл ажиллагааны журмаар тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг Хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  Д.ОЮУНЖАРГАЛ



**Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын  
“Орхон хөгжил” ХК-ийн  
2020 оны газар тариалангийн  
үйлдвэрлэл болон үйл ажиллагааны тайлан**

1. Тариалалтын талаар:

Тайлант 2020 онд тариалангийн ажилд ашиглах техник тоног төхөөрөмжийн засварыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. Мөн тоног төхөөрөмжөө шинэчлэн хор цацаг, үрлүүр, сийрүүлүүр хийсэн. 2018 онд 1 ширхэг комбайн зээлээр худалдаж авсан.

Тариалалтыг 5-р сарын 04-ны өдрөөс 5-р сарын 29-ныг дуустал хугацаанд нийт 900 га-д хийж гүйцэтгэв. Тарихын өмнөх боловсруулалтыг трактор, сийрүүлэгчээр гүйцэтгэсэн бөгөөд 160 тн үрийг 8-10 см-ийн гүнд тариалав.

2. Ургац хураалтын талаар;

Комбайны засварын ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэн 3 тразтор, 3 комбайныг бэлэн болгож ажиллуулсан. Хураалтын явцад комбайны эвдрэл бага зэрэг гарсан боловч цаг тухайд засварласан.

Тайлант онд 870 га талбайд уринш хийсэн. Уриншийн талбайд гербицид хороор боловсруулалт хийсэн. Хор цацах ажлыг 6-р сарын 15-аас 6-р сарын 25 хүртэл 10 хоног гүйцэтгэв. Уриншийн 2-р үеийн боловсруулалтыг 8-р сарын 8-аас эхэлж сийрүүлэлтийг 10 хоногт хийж гүйцэтгэлээ.

Ургац хураалт өөрийн автомашин техникийг ашиглан 40-45 хоног үргэлжлэв.

3. Үтрэмийн ажлын талаар;

Хураасан будаагаа өөрийн ачигч, цэвэрлэгч, сортлогч машиныг ашиглан стандартад нийцүүлэн “Алтан тариа” ХХК, “Өгөөж гурил” ХХК, Хөдөө аж ахуй сан, “Улаанбаатар гурил” ХХК-руу ачуулсан болно.

2021 онд 1 га-гаас 11,65 цн буюу нийт 1048,52 тн ургац хураасан бөгөөд үүнээс үрэнд 160 тн будаа хадгалж, 866,52 тн будаа борлуулж, 526 377,3 сая төгрөгний орлого олж, үүнээс 511003,6 сая төгрөгийн зардал гарсан бөгөөд 15373,87 сая төгрөгийн ашигтай ажилласан.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Д.ЖАРГАЛСАЙХАН

“Орхон Хөгжил” ХК-ийн ТУЗ-ийн  
2021 оны .. сарын ... өдрийн тогтоолын Хавсралт .1..

**“ОРХОН ХӨГЖИЛ” ХК –ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

“Орхон Хөгжил” ХК-ийн ээлжит хурал 2021 оны 04-р сарын 27-ны өдрийн 11 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, ЮБ март худалдааны төвийн 5-р давхарт 519 тоот өрөөнд болно.

Хувьцаа эзэмшигчийн овог: *Орхон Хөгжил* нэр: *Орхон Хөгжил*

Регистрийн дугаар: *УКБ707060* Санал өгөх хувьцааны тоо: *100621*

Бүртгэсэн: .....

овог: *Орхон Хөгжил* нэр: *Орхон Хөгжил*

№	Санал өгөх асуудал	Зөвшөөрсөн	Татгалсан	Түгэлсэн
1	Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;	✓		
2	2021 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах;	✓		
3	Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг батлах,	✓		
4	ТУЗ-ын ногдол ашиг тараахгүй талаар гаргасан тогтоолыг хэлэлцэх	✓		
5	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох	✓		

..... /гарын үсэг, тамга/

Хувьцаа эзэмшигч *Орхон Хөгжил* /гарын үсэг/

Санал авах хуудсыг ашиглах санамж

1. Засварласан, балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
2. Хувьцаа эзэмшигч өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч брокерийн пүүс дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
3. Хэрэв саналаа өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүний овог нэр, хаягийг дор бичих бөгөөд өөрийн санал авах хуудас, иргэний үнэмлэх, хувьцаа эзэмшиж буй баталгаа болон даалгаврын гэрээний хамт өгч явуулна.

Таныг төлөөлөх хүний овог: ..... нэр: .....

Оршин байгаа газрын хаяг: .....

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаар 88071296 утсаар лавлаж болно.

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон шалтгаан: .....

- Таныг төлөөлөх хүний овог: ..... нэр: .....
- Оршин байгаа газрын хаяг: .....
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаар 88071296 утсаар лавлаж болно.
5. Саналын хуудсыг хүчингүйд тооцсон шалтгаан: .....

“Орхон Хөгжил” ХК-ийн ТУЗ-ийн  
2021 оны .. сарын ... өдрийн тогтоолын Хавсралт

**“Орхон хөгжил” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын гишүүд:**

Тооллогын комиссын дарга: *Х.Сарнай* Х.Сарнай / Говь транс ложистикс ХХК-д хүний нөөц/

Тооллогын комиссын гишүүн: *Ж.Мөнхзаяа* Ж.Мөнхзаяа / “Вест Хилл” ХХК-д менежер/

ОРХОН ХӨГЖИЛ ХК-ИЙН ХУВЬЦАА

ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ИРЦ

Овог нэр	Тоо ширхэг	Гарын үсэг
Д.Оюунжаргал	100621	